**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**2025 оны жилийн эцсийн байдлаар**

2025.12.09

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийн тайлан |
|---|---|---|---|---|
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байрлуулж олон нийтэд хүргэх | Салбарын хэмжээнд түгээсэн нийт мэдээлэл, контентын тоо<br><br>1/ 4900 | • 2025.09.26-нд "Авилгын эсрэг хамтдаа нэгдье" видео контент бэлтгэн www.ehemut.mn веб хуудас болон Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв пейж хуудсанд байршуулсан. Тус контент 4900 хүнд хүрсэн байна.<br><br>• Төвийн www.ehemut.mn веб хуудсанд Авлигын эсрэг булан нээж, ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, АТГ-аас |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | бэлтгэсэн Авлигын эсрэг нэгдье шторк, инфогрфик, зурагт хуудас 10 сурталчигааг байршуулан олон нийтэд хүргэж байна. |
| | | 1.2 Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | Өдөрлөгийн үр дүн, оролцогчдын тоо<br>2/282 | • 2025.04.07-нд төвийн нийт 32 ахлах сувилагч нарт “Авлига болон авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх” тухай ойлголт мэдээллийг өгсөн.<br><br>• 2025.05.09-нд тус төвөөс зохион байгуулсан “Үйлчлүүлэгчдээ сонсоё” өдөрлөгийн үеэр 250 гаруй иргэд үйлчлүүлэгчид Авлигын эсрэг гарын авлагуудыг тарааж түгээн сурталчилсан |
| | | 1.3 Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах | Сургалтын үр дүн, тайлан, сургалтад оролцогчдын тоо<br><br>1/120 | • 2025.09.23-ны өдөр Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн , ажил нарт “Авилга, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтанд 120 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |  |
| 2. | Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1 "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | Журмын хэрэгжилтийн үнэлж, хэрэгжилтийг сайжруулахаар авсан арга хэмжээний дүн | • Тус төв төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг мөрдөн ажиллаж байна.<br>• Төвийн ёс зүйн салбар хорооны зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах зарыг 2025 оны 03 дугаар сард www.ehemut.mn веб сайт дээр байрлуулан, нэг хүний материал сонгон шалгаруулалтанд ирж, тухайн хүнийг Ёс зүйн салбар хорооны гишүүнээр томилсон<br>• Төвийн захирлын 2025 оны А/05, А/10, А/11, А/12, А/13, А/14 тоот Тендерийн хороо байгуулах тухай тушаалд тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн 3/1-ээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна.<br>• 2026 онд Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн салбарын нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагааг нэмэгдүүлэх | Хамтран ажилласан мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагын тоо 1/110 | • 2025.09.23-нд ЭХЭМҮТ-ийн захиргаа, Ёс зүйн салбар хороо ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран "Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" сургалт зохион байгуулсан. |
| | | 2.3 Эрүүл мэндийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулж замаар төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах | Мэргэжлийн нэгдсэн холбоонд орсон байгууллагын тоо | • Хамаарахгүй |
| | | 2.4 Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | Ил тод нээлттэй мэдээлсэн мэдээллийн тоо | • Монгол улсын "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль", 2015 оны "Шилэн дансны тухай" хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн төвийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.<br>• 2025 онд www.shilendans.gov.mn сайтад санхүүгийн дараах мэдээллүүдийг байршуулсан байна. Үүнд:<br>  ○ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ<br>  ○ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <ul><li>Тавзн сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг</li><li>Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр</li><li>Хандив, тусламжийн орлого</li><li>Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан</li><li>Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</li><li>Аудитын зөвлөмж, албан шаардлагын биелэтийг гарган шилэн данс, шилэн ажиллагаа болон аудитын нэгдсэн мэдээллийг санд илгээсэн.</li><li>Байгууллагын вэб хуудсанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр байршуулсан</li></ul> |
| | | 2.5 Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүнд суртал, ойлгомжгүй байдлыг арилгах зорилгоор цахим үйлчилгээг шинээр нэвтрүүлэх | Цахим шилжүүлсэн үйлчилгээний тоо | <ul><li>Хүүхдийн болон Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн лавлах хэсэг, Яаралтай тусламжийн тасгууд, Хүүхдийн эмнэлгийн өргөтгөлийн хэсэг зэрэг 5 байршлын хүлээлгийн хэсгүүдэд урсдаг мэдээллийн самбар, Хүүхдийн зөвлөх поликлиник, үйл онош зүйн хэсгийн үзлэгийн кабинетын үүдэнд үйлчлүүлэгчийн нэр, үзлэгийн цаг, дугаарыг харуулсан 27, Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн үзлэгийн кабинетын үүдэнд 12 дэлгэц, нийт 39 дэлгэц, Нярайн эрчимт эмчилгээ, Хүүхдийн эрчимт эмчилгээ, Мэс заслын эрчимт эмчилгээний тасгийн үүдэнд 4 дэлгэц тус тус байршуулан үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээллийг ар гэрийхэнд түгээн ажиллаж байна.</li><li>Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр иргэдэд</li></ul> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зориулсан мэдээ, мэдээллийг бүх кабинетуудын гадаах дэлгэцэнд нийт 8 мэдээллийг 2-3 минутын зайтай солигдож байхаар шинээр байрлуулсан.<br>• Хүүхдийн зөвлөх поликлиникийн товлолт үйлчилгээнд "НЭГ ЦЭГ"-ийн үйлчилгээг нэвтрүүлж, үйлчлүүлэгч узүүлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын товлолын дугаарыг нэг цахим бүртгэгчээс авч хэвшсэн.<br>• 2025 оны 10 дугаар сард иргэдийн бөөгнөрлийг тарах зорилгоор үзлэгийн кабинетуудын байрлалыг өөрчлөх, удаан ажиллагаатай болсон 70 компьютерийн хурдын нэмж, 20 компьютерыг шинээр сольсон. |
| | | 2.6 Авлигатай тэмцэх газартай хамтран Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | • Хамаарахгүй |
| 3. | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1 Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байхад байгууллагын удирдлагын баг тасралтгүй хяналт тавих, зөрчил үүссэн нөхцөл байдал яаралтай арга хэмжээ авч ажиллах | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу ЭХЭМҮТ-ийн Тендерийн хороо байгуулах тухай 2025 оны А/05, А/10, А/11, А/12, А/13, А/14 тоот тушаал, тендерийн хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчийн мэдэгдлийг хуулийн хугацаанд нь шилэн дансанд байршуулсан. 2025 онд ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдол байхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.2 Салбарын хэмжээнд гарч буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн гомдлыг шалтгаан нөхцөлийг тодорхойлох | Салбарын өргөдөл гомдлын нэгдсэн тайлан, дүн шинжилгээ | • Тус төв санал хүсэлтийг 76112180, 362205, “ЭХЭМҮТ-ийн удирдах ажилтнуудын иргэдтэй уулзах хуваарь”, Засгийн газрын 11-11 төв, санал хүсэлтийн дэвтэр, хайрцаг, цахим хуудас, сэтгэл ханамжийн судалгаа зэрэг хэлбэрээр авдаг.<br>• Цахим хуудас ашиглан иргэд болон өөрийн ажилчид санал, хүсэлтээ чөлөөтэй тавих боломжийг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд тус төвтэй холбоотой санал гомдлын булан нээн ажиллуулж байна. Цахим хуудас байгууллагаас гадагшаа нээлттэй тул форум-д хүн бүр саналаа бичиж болно. Төвийн гадаад цахим хуудсанд асуулт хариулт гэсэн цэс бий болгож, иргэдийн асуултанд хариулж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ явуулж байна.<br>• Нийт 56 төрөлжсөн мэргэжлийн кабинет, 32 тасаг нэгжийн мэдээллийн самбарт ил тод байршуулан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, асуудлыг цаг алдалгүй түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.<br>• 2025 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар тус төвд ЭМЯ, ЭМГ болон холбогдох яам, газруудаас нийт 1209 албан бичиг ирсэн байна. Үүнээс:<br>  ○ ЭМЯ-наас 295<br>  ○ Сайдын тушаал, албан даалгавар 32<br>  ○ Өргөдөл, хүсэлт 118<br>• 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 11-11 төвөөр нийт 265 өргөдөл, гомдол, хүсэлт, талархал ирсэн байна. Үүнээс<br>  ○ Дэмжлэг хүсэхтэй холбоотой 76<br>  ○ Бусад-109,<br>  ○ талархал-80 байна.<br>• Шийдвэрлэлт 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.3 Төгсөлтийн дараах сургалтын элсэлт, элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж эрсдэлийг бууруулах | Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | • 2025 онд төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын төгсөлтийн шалгалтыг 209 эмч, сувилагч, эх баригчаас, үндсэн мэргэшлийн 2,3-р улирлын шалгалтыг 93 резидент эмч нараас тус бүр 100% цахим хэлбэрээр зохион байгуулсан. |
| 4. | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1 Эрүүл мэндийн байгууллага бүр авлигын эсрэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайлагнах | Төлөвлөгөөний биелэлт, тайлан<br>100% | • ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сард төвийн захирлаар батлуулан хэрэгжүүлэн тайланг хагас бүтэн жилээр гарган ажиллаж байна. |
| | | 4.2 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр байгууллагын удирдлага шинэ ажил санаачлан хэрэгжүүлж, сурталчлах | Хэрэгжүүлсэн шинэ санал, санаачилгын тоо, хэрэгжилтийн тайлан<br>2/278 | • Төвийн захиргаа, Ёс зүйн салбар хороо хамтран 2025.06.24-нд Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн шинэ ойлголт сэдэвт сургалт /168 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн/ зохион байгуулсан. Уг сургалтыг АШУҮИС-Био-Анагаахын Сургуулийн Биологийн тэнхмийн профессор Ардын багш, Гавьяат багш, Доктор, Профессор А.Гүрбадам, хуульч, их эмч Б.Одгэрэл нар "Мэндлэх, хүндлэх ёсон, ёс зүйн хэм хэмжээ", "Ажлын байрны эмх цэгц ба албаны хувцаслалтын соёл", "Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн байдлыг сайжруулах асуудал" сэдвээр зохион байгуулж, 1 багц олгосон байна.<br>• 2025.09.23-нд ЭХЭМҮТ-ийн захиргаа, Ёс зүйн салбар хороо ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран "Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" сургалт зохион байгуулсан. ЭМЯ-ны ЁЗХХ-ны дарга АУ-ны доктор дэд профессор Д.Оюунбилэг, Иргэдийн өргөдөл гомдол хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн дарга Ш.Оюунчимэг, ЁЗХХ- ны гишүүн АШУ-ны доктор профессор Б.Саранцэцэг багш нар ёс зүйн сургалтыг удирдан орж, сургалтанд ЭХЭМҮТ-ийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нарын 110 гаруй ажилтан хамрагдсан |
| | | 4.3 Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл шинээр олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчилж боловсруулах | Боловсруулсан судалгаа, мэдээлэл, эрх зүйн баримт бичиг | • Хамаарахгүй |

ХЯНАСАН: ЗАХИРАЛ ______________ Ж.ОТГОНБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ______________ Б.БОЛОР